



БҮРТГЭЛТЭЙ ХУВЬЦААТ КОМПАНИУДЫН  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ,  
ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГАД

**МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ  
ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИ**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
1 дүгээр хороо, Д.Сүхбаатарын талбай 3,  
Утас: 31 05 01, 31 37 47, Факс: (976-11) 32 51 70,  
E-mail: info@mse.mn, Website: www.mse.mn

2020.01.14 № 01/27

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

□ Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. □

Монголын хөрөнгийн бирж болон хөрөнгийн зах зээлийн хувьд 2019 он ололт амжилтаар дүүрэн жил байлаа. 2019 онд нийт арилжааны үнийн дүн 143.0 тэрбум төгрөгт хүрснээс гадна 4 компани үнэт цаасаа олон нийтэд санал болгож, 42.5 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлсэн нь Монголын хөрөнгийн зах зээлийн 29 жилийн түүхэн дэх анхдагч зах зээлийн арилжааны хамгийн өндөр дүн байлаа.

Хөрөнгө оруулагчдын итгэлийг нэмэгдүүлэх, хөрөнгийн зах зээлийн чадавхийг дээшлүүлэхэд үргэлж хамтран ажилладаг бүртгэлтэй хувьцаат компаниуд Та бүхэндээ талархал илэрхийлье.

Бид цаашид үнэт цаас гаргагчдын нэр хүндийг өсгөх, хөрөнгө оруулалт татах таатай орчинг бүрдүүлэхийг зорьж ажиллах болно. Үүнд та бүхний оролцоо чухал тул МХБ-д бүртгэлтэй нээлттэй хувьцаат компаниудын Төлөөлөн удирдах зөвлөл болон эрх бүхий албан тушаалтнуудын зүгээс 2020 онд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэн, хууль журмаар хүлээсэн үүргээ биелүүлэн, тайлан мэдээллээ цаг тухайд нь ирүүлж хамтран ажиллахыг хүсье. Үүнд:

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 443 дугаар тогтоолоор батлагдсан “Үнэт цаас гаргагчийн мэдээллийн ил тод байдлын журам”-ын 2.2-т заасны дагуу жилийн үйл ажиллагааны тайланг аудитаар баталгаажсан санхүүгийн тайлангийн хамт 2020 оны 4 дүгээр сарын 01-ний өдрийн дотор, хагас жилийн санхүүгийн тайланг 7 дугаар сарын 20 ны өдрийн дотор, хагас жилийн үйл ажиллагааны тайланг 8 дугаар сарын 01-ний өдрийн дотор тус тус ирүүлэх;
2. Дээрх журмын 3.2-т заасан тухай бүр нийтэд хүргэх мэдээллийг тухайн үйл явдал, өөрчлөлт болсноос хойш ажлын 1 өдөрт багтаан ирүүлэх;
3. Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 377 дугаар тогтоолоор батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх, хяналт гавих журам”-ын дагуу ээлжит хурлаа зарлаж, материал шийдвэрээ хугацаанд нь ирүүлэх;

4. Компанийн тухай хуулийн 46.5-д заасны дагуу Ногдол ашиг тараах эсэх тухай шийдвэрээ 2 дугаар сарын 20-ны дотор, тус хуулийн 46.14, 46.15-д заасны дагуу ногдол ашиг хуваарилалтын тайланг ирүүлэх;
5. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 56, 79 дугаар зүйл, Компанийн тухай хуулийн 88 дугаар зүйл, 88.4 дахь заалт, СЗХ-ны “Үнэт цаас гаргагчаас мэдээллийг нийтэд тогтмол хүргэх тухай журам”, “Монголын компанийн засаглалын кодекс”-ийн 7.1, 7.2, 7.3 дахь заалтуудыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон өөрийн цахим хуудсыг байнга ажиллуулж, хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигч нартаа зориулсан тусгай цэсийг бий болгож, цаашид хөгжүүлэн ажиллах;
6. “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 22 дугаар зүйлийн 11-т зааснаар бүртгэлтэй хувьцаат компани нь жилийн үйлчилгээний хөлсийг тухайн оны I дүгээр улиралд багтаан МХБ-ийн дансанд төлөхөөр туссан тул 2020 он болон өмнөх онуудын төлбөрийн үлдэгдлийг 2020 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн дотор төлж, тооцоо нийлсэн акт үйлдэх;
7. МХБ-ийн Үнэт цаасны бүртгэлийн журам 2018, 2019 онд гэрээгээ шинэчлэн байгуулаагүй компаниуд МХБ-ийн цахим хуудас <http://mse.mn/mn/content/list/221/>-т байршуулсан гэрээний загварын дагуу гэрээнд гарын үсэг зурж, баталгаажуулан 2 хувь үйлдэж тус тус ирүүлнэ үү.

Та бүхнийг хүлээсэн үүргийнхээ дагуу нээлттэй ил тод байх зарчмыг сахиж, хөрөнгийн зах зээлийн хөгжилд хувь нэмрээ оруулан бидэнтэй хамтран ажиллана гэдэгт итгэж байна.

*Хавсралт:* Мэдээлэл ирүүлэх хуанли, тооцоо нийлэх акт, нэхэмжлэх, нийт 4 хуудас.

Холбогдох хаяг:  
Бүртгэлийн алба  
Монголын хөрөнгийн бирж ТӨХК  
Сүхбаатарын талбай-3  
Улаанбаатар 15160, Монгол улс  
Утас : (+976)-11-313511 /5115, 2111/, 11-321411 /5120, 5125/  
Факс: (+976)-11-325170  
Вэб : [www.mse.mn](http://www.mse.mn)

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Х.АЛТАЙ

## МХБ-д мэдээлэл ирүүлэх хуанли

## • 1 дүгээр улирал

№	Тогтмол ирүүлэх мэдээллийн төрөл	Хууль, журмын заалт	Хугацаа
1	Жилийн эцсийн санхүүгийн тайлан	ҮЦЗЗТХ 20.1.6, НББ хуулийн 10.3	02 сарын 10 -ны дотор /компанийн нэгдэл 03.01/
2	Ногдол ашиг тараах эсэх тухай шийдвэр	КТХ-ийн 46.5	Санхүүгийн жил дууссанаас хойш 50 хоногийн дотор буюу 02 сарын 19-ны дотор
3	Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын мэдэгдэл	КТХ-ийн 60.3, 60.4, СЗХ-ны "Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам"-ын 3.1	03 сарын 21-ны дотор +/-3-5 хоног/
4	Аудитын дүгнэлт	ҮЦЗЗТХ 20.1.6, Аудитын тухай хуулийн 10.2, НББ хууль 9.7	ХЭХ-аас 2-оос доошгүй долоо хоногийн өмнө /ТӨХК 03.15, Банк 03.31/
5	Жилийн үйл ажиллагааны тайлан*	СЗХ-ны "Үнэт цаас гаргагчийн мэдээллийн ил тод байдлын тухай журам"-ын 2.2	03 сарын 31-ний дотор /04.01-ний дотор/
6	Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гарсан шийдвэр, хурлын тэмдэглэл	КТХ-ийн 74.1, ҮЦЗЗТХ 20.1.8, 56.1.6, 56.2.3, СЗХ-ны "ХК-ийн ХЭХ-ын зар хүргэх журам"-ын 2.10	Хурал хуралдсанаас хойш ажлын 3-15 өдрийн дотор

## • 2 дугаар улирал

№	Тогтмол ирүүлэх мэдээллийн төрөл	Хууль, журмын заалт	Хугацаа
1	Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулах сүүлчийн хугацаа	КТХ-ийн 59.4	04 сарын 30-ны дотор
2	Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гарсан шийдвэр, хурлын тэмдэглэл	КТХ-ийн 74.1, ҮЦЗЗТХ 20.1.8, 56.1.6, 56.2.3, СЗХ-ны "ХК-ийн ХЭХ-ын зар хүргэх журам"-ын 2.12	Хурал хуралдсанаас хойш ажлын 3-15 өдрийн дотор /сүүлчийн хугацаа 05 сарын 20/

## • 3 дугаар улирал

№	Тогтмол ирүүлэх мэдээллийн төрөл	Хууль, журмын заалт	Хугацаа
1	Хагас жилийн санхүүгийн тайлан	НББ хуулийн 10.3, СЗХ-ны "Үнэт цаас гаргагчийн мэдээллийн ил тод байдлын тухай журам"-ын 1.7	07 сарын 20-ны дотор
2	Хагас жилийн үйл ажиллагааны тайлан*	СЗХ-ны "Үнэт цаас гаргагчийн мэдээллийн ил тод байдлын тухай журам"-ын 2.2, 2.4	08 сарын 01-ний дотор

## • Бусад

		Хууль, журмын заалт	Хугацаа
1	Тухай бүр нийтэд мэдээлэх мэдээлэл	ҮЦЗЗТХ-56.1, 56.2, СЗХ-ны "Үнэт цаас гаргагчийн мэдээллийн ил тод байдлын тухай журам"-ын 3-р зүйл, 3.2	Тухайн нөхцөл байдал үүссэнээс хойш ажлын 1 өдрийн дотор
2	Ногдол ашиг хуваарилалтын тайланг ХЭХ-д тайлагнах, МХБ-д ирүүлэх	КТХ 46.14 КТХ 46.15	ХЭХ-ын өдөр/хуваарилж дууссанаас хойш ажлын 15 өдрийн дотор
3	Жилийн үйлчилгээний хөлс төлөх	МХБ-ийн Бүртгэлийн журам 22.11, Бүртгэлийн гэрээ 2.1.3, 2.4	03 сарын 31-ний дотор

Товчилсон үгийн тайлбар:

КТХ - Компанийн тухай хууль  
НББ хууль - Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль  
ҮЦЗЗТХ - Үнэт цаасны зах зээлийн тухай хууль  
ХЭХ - Хувьцаа эзэмшигчдийн хурал